

**ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
2024 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД**

1. БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ХЭЛЭЛЦЭЭР 2024

Бүгд Найрамдах Мальта Улсын Меллиеха хотод хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэгч улсын бүртгэл дамжих үйлдэл болон олон улсын хориг арга хэмжээнээс урьдчилан сэргийлэх “БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ХЭЛЭЛЦЭЭР 2024” /RISC 2024/ сэдэвт олон улсын хурал 2024 оны 03-р сарын 19-24-ний өдрүүдэд боллоо. Тус хуралд Зам, тээврийн яам болон Далайн захиргааны төлөөллүүд амжилттай оролцсон.

2. ДАЛАЙН САЛБАРЫН БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХ

Бүгд Найрамдах Мальта Улсад байрлах Олон улсын далайн хуулийн институтын захирал Доктор Норман Мартинез Гуттиеррастай 03 дугаар сарын 22-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд Монгол Улсын далайн салбарын боловсон хүчин бэлтгэх асуудлаар цаашид хамтран ажиллахаар санал солилцсон.

3. ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ QR КОДТОЙ БОЛГОВ

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцнуудад бүртгэлийн цахим гэрчилгээ олгож цаасан гэрчилгээ хэвлэхтэй холбогдон гарах зардлыг хэмнэж чадсан ба хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг QR код уншуулан баталгаажуулах боломжтой болсон.

4. “ХУУРАЙ БООМТЫН ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” СЭДЭВТ БҮС НУТГИЙН СЕМИНАР БОЛЛОО (2024 ОНЫ 11.13)

Семинарт 70 гаруй албаны төлөөлөл, эрдэмтэн судлаачид төлөөлөл оролцсон бөгөөд Монгол Улс НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, Нийгмийн комисс (АНДЭЗНК)-тай тогтмол хамтран ажиллаж хуурай боомтыг байгуулахад шаардагдах техникийн тусламж, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

5. УСАН ЗАМЫН ХӨВДӨГ ЗОГСООЛТТОЙ БОЛЛОО

Далайн захиргаа өөрийн эх үүсвэрийн санхүүжилтээр Архангай аймгийн Өгий нуур болон Хөвсгөл нуурын эрэгт усан замын хөвдөг зогсоолуудыг тус тус суурилуулсан.

6. ХӨВСГӨЛ НУУРТ ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ХИЙХ АВРАХ ЗАВЬТАЙ БОЛОВ

Усан замын тээврийн хяналтын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор ХБНГУ-аас тусгай тоноглол бүхий аврах завийг 09 -р сарын 17-нд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд хүлээн авлаа.

Уг завь нь далай, тэнгисийн усанд тэсвэртэй, 5,5 тонн жинтэй, 8.5м урт бөгөдөд харилцаа холбооны техник тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон.

Аврах завийг Хөвсгөл нуурт эргүүл хяналтад ашиглахаас гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хөвсгөл нуурт живсэн автомашин техникийг татан гаргах, байршлыг тогтоох судалгаа шинжилгээний ажилд оролцож байна.

7. МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА БНСУ-ЫН ДАЛАЙН ИНСТИТУТТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Далайн захиргааны дарга Б.Сайнбаяр тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-ын Далайн институт хооронд далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд талууд далайн эдийн засаг, далайн болон усан замын тээвэр, загас агнуур, далайн боомт, хуурай боомт, далайн тээвэр, логистикийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллана.

8. МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА ТАЙЛАНДЫН ДАЛАЙН ЗАХИРГААТАЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Далайн захиргаа Тайландын Хаант Улсын Далайн захиргаа хооронд далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг 2024 оны 11-р сарын 01-ны өдөр байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд талууд далайн эдийн засаг, далайн болон усан замын тээвэр, далайн боомт, логистик, далайн тээврийн салбартай холбоотой бодлого, боловсруулах чиглэлээр хамтарсан судалгаа хийж, далайн тээвэр, логистикийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллах болно.